

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт болон 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 3 тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн дараах заалтуудад өөрчлөлт оруулсугай.

1.1. Компанийн дүрмийн 8.1.3 дахь заалтад “Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээг тогтоох” гэж;

1.2. Компанийн дүрмийн 8.2 дахь заалтад “Компанийн ТУЗ нь 9-өөс 11 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 (гурав) жилийн хугацаатай сонгох бөгөөд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ” гэж;

1.3. Компанийн дүрмийн 8.15 дахь заалтад “Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудитын хороо 2. Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 3. Санхүү, эрсдэл, зээлийн хороо, 4. Цалин, урамшууллын хороог тус тус байгуулан ажиллуулна”.

1.4. Компанийн дүрмийн 8.17 дахь заалтад “Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчлөх;

2. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд дараах заалтуудыг нэмсүгэй.

2.1. Компанийн дүрмийн 8.19 дэх заалтад “Цалин, урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ” гэж;

2.2. Компанийн дүрмийн 8.19.1 дэх заалтад “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” гэж;

2.3. Компанийн дүрмийн 8.19.2 дахь заалтад “Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг

тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” гэж;

2.4. Компанийн дүрмийн 8.19.3 дахь заалтад “Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх” гэж нэмэх;

2.5. Компанийн дүрмийн 8.20 дахь заалтад “ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй” гэж нэмэх

3. Компанийн дүрмийн 8.17.9, 8.17.10, 8.17.11 дэх заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.

4. Энэхүү шийдвэрийн 1, 2, 3-т заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

5. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ